

**ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРТ ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖ, ХӨГЖЛИЙН
БАНКНЫ ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСЛҮҮДИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Төслийн нэр	Төслийн зорилго
1	Тавантолгойн цахилгаан станцын төсөл	Тавантолгойн нүүрсний орд газрын түшиглэн 450 МВт-ын цахилгаан станц барьж өмнийн говийн стратегийн орд газруудыг Эрчим хүчээр хангах.
2	Дулааны 4 дүгээр цахилгаан станцын үр ашгийг дээшлүүлэх төсөл	Улаанбаатар хотын 4 дүгээр цахилгаан станцын үндсэн тоноглолуудын найдвартай ажиллагааг дээшлүүлж эрчим хүчний системийн тогтвортой ажиллагааг хангах.
3	Эрчим хүчний үр ашиг III+ төсөл	Эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх хууль зүйн орчныг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх
4	Эрдэнэбүрэнгийн УЦС-ын төсөл	Баруун бүсийн эрчим хүчний өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг дотоодын найдвартай эх үүсвэрээр хангах, импортын цахилгаан эрчим хүчний хэмжээг бууруулан, баруун бүсийн эрчим хүчний хэрэгцээг хангах 64 МВт-ын хүчин чадал бүхий усан цахилгаан станцыг барьж байгуулах.
5	Дулааны 3 дугаар цахилгаан станцын түлш дамжуулах цехийн шинэчлэлтийн төсөл	Тус станцын өндөр даралтын хэсэг дэх зуухнуудад зориулсан нүүрс дамжуулах системийг бүрэн автоматжуулж, ажиллагааг удирдлага, хяналтын системийг автоматжуулан техникийн найдвартай ажиллагааг хангах.
6	Дарханы дулааны цахилгаан станцын турбины шинэчлэлт төсөл	Төвийн бүсийн болон тухайн бүс нутгийн цахилгаан, дулааны эрчим хүчний өсөн нэмэгдэж буй хэрэглээг найдвартай хангах зорилгоор тус станцын хүчин чадлыг 35 МВт-аар нэмэгдүүлэх, станцын техникийн найдвартай ажиллагааг хангах.
7	Улаанбаатар-Мандалговь ЦДАШ, дэд станцын төсөл болон Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын шинэчлэлтийн төсөл	Улаанбаатар хотоос Мандалговь руу 330 кВ-ын ЦДАШ, дэд станц барьж өмнийн говийг төвийн эрчим хүчний системтэй холбох, Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 35 МВт-аар нэмэгдүүлэхээр уг төсөл нь хэрэгжиж байгаа болно.
8	Дэлхийн банкны “Эрчим хүчний төсөл 2”	Эрчим хүчний салбар, бүс нутгийн цахилгаан хангамжийг сайжруулах зорилгоор түгээх компаниудын эрчим хүчний алдагдлыг бууруулж, эдийн засгийн чадавхийг сайжруулах, техникийн аюулгүй найдвартай ажиллагааг хангах Баруун бүс, Алтай-Улиастай, Зүүн бүсийн эрчим хүчний хангамжийг сайжруулах зорилгоор Сэргээгдэх эрчим хүчийг дэлгэрүүлэх хөтөлбөр төслийн хүрээнд Дэлхийн банкны санхүүжилтээр 10 МВт-ын нарны станц барих
9	Багануурын цахилгаан станцын төсөл	Багануурын нүүрсний уурхайг түшиглэсэн том оврын цахилгаан станц (700 МВт) барьснаар төвийн бүс, дорнод бүс, говийн бүсийн цахилгаан хангамжийн найдвартай эх үүсвэрийг бий болгох